Төв аймгийн насанд хүрэгчдийн хорт зуршлын хэрэглээг судалсан дүн

М.Хонгорзул[1], Д.Хишигтогтох[1], Б. Билэгт[1], Ц. Нямсүрэн[2]

[1,2]АШУҮИС, НЭМС

Үндэслэл: Халдварт бус өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлсийн тархалт нь Монгол оронд төдийгүй бүс нутаг, дэлхийн хэмжээнд хүн амын эрүүл мэнд, нийгэм эдийн засагт дарамт үүсгэсээр байгаа нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж байна[1]. Манай улсад халдварт бус өвчний (ХБӨ) өвчлөлийн чиглэлээр үндэсний хэмжээний 3 удаагийн (2005, 2009, 2013) шаталсан судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнгээр хүн амын дунд ХБӨ-ний тархалт жилээс жилд нэмэгдэж, насны хувьд залуужин, эрэгтэйчүүдийн дунд тархалт, эрсдэл өндөртэй байна. Иймд цаашид халдварт бус өвчний эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээг нотолгоонд суурилж, бүс нутгийн өвөрмөц онцлог, хүн ам зүйн бүтэц, зан заншил, эрүүл мэндийн тусламж хайх зан үйлтэй нь холбон судлаж, улмаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, менежментийг сайжруулах шаардлагатай байгаа юм.

Зорилго: Төв аймгийн насанд хүрэгчдийн дундах ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйл болох архи, тамхины хэрэглээ, тэдний мэдлэг, хандлагыг судлах зорилготой юм.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгааг хүн амд суурилж, төв аймгийн 26 сумдаас хүн амыг төлөөлөхүйцээр 18-65 насны нийт 2824 хүнийг хамруулж, түүврийн алдааг нэмэлтээр тооцон аналитик судалгааны агшингийн аргаар хийсэн. Судалгааны мэдээ материалыг асуумж болон биеийн хэмжилт хийн цуглуулсан.

Үр дүн: Судалгаанд хамрагдагсдын 24 хувь нь сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн, тэдний 66.5 хувь нь эрэгтэйчүүд, 33.5 хувь нь эмэгтэйчүүд байв. Архи согтууруулах ундаа хэрэглэсэн хүмүүсийн 40.9 хувь нь сард 2-3 удаа, 43.7 хувь нь сард нэг ба түүнээс дээш давтамжтай хэрэглэдэг, нэг удаад уудааг уухдаа 9.1 (95%, их 8.7-9.6) стандарт уултын хэмжээгээр хэрэглэжээ. Согтууруулах ундаа хэрэглэдэг дийлэнх оролцогч буюу 85.2 хувь нь архины хэрэглээний асуудлаа гадаад хүчин зүйлд хамаатуулах хандлагатай (найз нөхдийн нөлөөнөөс болдог, баяр ёслолын үеэр уудаг г.м), 30 орчим хувь нь согтууруулах ундааны хэрэглээгээ өөрчлөх бодолгүй гэсэн зан үйлтэй байна. Судалгааны дүнгээр нийт хүн амын 19.6 хувь, эрэгтэйчүүдийн 28.7 хувь, эмэгтэйчүүдийн 11.1 хувь тамхи тамхи татдаг байна. Тамхи хэрэглэгчдийн ихэнх нь (94.7%) өдөр бүр татдаг бол тэдний 30 гаруй хувь нь өдөрт 5-аас дээш ширхэг, 50 гаруй хувь нь 10-аас дээш ширхэг тамхи татдаг бөгөөд дунджаар 20 (95%, их 19-20) настайгаасаа тамхи татаж эхэлжээ. Тэдний 59.1 хувь нь тамхи татдаг асуудлаа найз нөхдийн нөлөө гэх мэтээр гадаад хүчин зүйлд хамаатуулж байна. Судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын 4 нь (41.4%) гэрийн дотоод орчинд, 4 хүн тутмын 1 нь (25.7%) ажлын байрандаа дам тамхидалтад өртөж байна. Тамхи татдаг хүн амын 35.6 хувь нь амьдралынхаа хугацаанд ямар нэг байдлаар тамхинаас гарах оролдлого хийж байсан, 40 орчим хувь нь тамхинаас гарах талаар бодож байгаагүй гэжээ.

Дүгнэлт: Судалгаанд хамрагдагсдын 4 хүн тутмын нэг нь архи, согтууруулах ундаа хэрэглэдэг, үүнд эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдээс 2 дахин их байгаа нь анхаарал татаж байгаа юм. Түүнчлэн нэг удаад уух архины хэмжээгээ 6 ба түүнээс дээш стандарт уултаар хэтрүүлэн хэрэглэдэг эрсдэлт зан үйлтэй байна. Нийт судалгаанд хамрагдагсдын 5 хүн тутмын нэг нь тамхи татдаг, үүний 88 хувь нь эрчүүд байна. Тамхи татдаг нийт хүмүүсийн 94.7 хувь нь өдөр бүр дунджаар 10.3 ширхэг тамхи татдаг буюу тамхины өндөр хэрэглээтэй байна.

Түлхүүр үг: архи тамхины хэрэглээ, эрсдэлт зан үйл

Evaluation of the negative behaviors among adolescents In Tov Province

Khongorzul M [1], Khishigtogtokh D[1], Bilegt B[1], Nyamsuren Ts[2]

[1,2]School of public health. MNUMS

Introduction: Prevalence of non-communicable diseases and their risk factors are becoming a challenging problem of public health, which makes so much burden on community health and social economics, not only in Mongolia but also worldwide. The nationwide survey on the prevalence of non-communicable disease's risk factors was conducted in Mongolia 3 times. (2005,2009,2013).

According to the survey, the prevalence of risk factors for non-communicable diseases are increasing year by year in the general population, and which are getting higher in young people, especially in men. So, further activities against non-communicable diseases need to be based on evidence, investigated the specifics of the region, it's demographic structure, habits, and behaviors seeking health care of the population, and thus plan and improve management of the activities.

Purpose: This study aims to determine the prevalence of alcohol and Tabaco usage among the adolescence of 26 sums of Tov province, which are the risk factors for non-communicable diseases.

Materials and methods: A multi-stage random sampling method carried out to select participants from the target population. A total of 2824 individuals were involved in the survey. The individuals who agreed to participate in a survey must be a recruit. The approximate time required for one participant was 15-20 minutes. The data collector checks whether if the questionnaire fully completed, then individuals signed on the participant's survey consent forms.

Conclusion: One in every four participants were current drinkers, whereas the proportion of men was twice as high as compared to women, which requires appropriate attention. More than 6 drinks on one occasion are common. One in every 5 participants were current smokers, 88 percent of whom are men. 94.7% of smokers smoke an average of 10.3 cigarettes per day, which means those people have high Tabaco usage.

Keywords: alcohol and tabaco usage, negative behaviors